



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 05

№ 01/05ДУА - 2018/73/СТА-ТЦЛЗ Мандалговь хот

Г

Т

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Луус сумын Соёлын төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар. **78,200.00** /Далан найман мянга хоёр зуун/ төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Орон нутгийн өмчийн байр түрээслэсний орлого болох 78,200.00 /Далан найман мянга хоёр зуун/ төгрөгийг төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын дансанд төвлөрүүлээгүй. Энэ нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 51 тоот тогтоолын 2.7-д /орон нутгийн өмчийг түрээсээр эзэмшиүүлэх хуулийн этгээд нь оры нутгийн өмчийг түрээсээр эзэмшиүүлж олсон орлогын 90 хувийг Байгууллагын оворийн орлогод төвлөрүүлнэ. Тус орлогын 10 хувийг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын дансанд сар тутам төвлөрүүлнэ./ заасныг зөрчсөн.
2. Завсрын аудитаар илэрсэн зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д /Аудитын явцад шээрсэн толбор, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомжс, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагыг тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад шээрсэн толборийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор толборийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.6-т /Аудитаар шээрсэн зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй/, 4.1.7-д /Хууль тогтоомж зорчсон алдаа, зөрчлийг таслан зогсоож давтан гаргуулахгүй байх үр нолоотэй гэж үзсэн бусад похцол байдал / гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Цаашид түрээсийн орлогын 10 хувийг төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлого 100080000953 дансанд төвлөрүүлэх;
2. Өмнө нь өгсөн зөвлөмжийн дагуу номын санчийн цахим бүргэлийн ном, санхүүгийн программд бүртгэлтэй номын зөрүүг арилгах.

Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2018 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт ирүүлэхийг Луус сумын Соёлын төвийн эрхлэгч Л.Баярсайхан, нягтлан бодогч Н.Нармандах нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

АУДИТОР

Т. БАТСАЙХАН

4317144713
ЗОДОО М. О. А. А. А. А. А.

ЗӨВШӨӨРСӨН:

ЭРХЛЭГЧ

НЯГТЛАН БОДОГЧ

ТТБ8520 № 9033327

Л.БАЯРСАЙХАН

Н.НАРМАНДАХ

¹Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, толборийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/